

«ДОРНОДАХИНЫ СУДЛАЛЫН АСУУДАЛ» СЭТГҮҮЛИЙН РЕДАКЦИД ИРЖ БУЙ ЗАХИДЛЫН ТОЙМООС

Манай уншигчдаас тус сэтгүүлийн редакцид захидал ирүүлж сэтгүүлийн ололт дутагдлыг дурдахын зэрэгцээ сэтгүүлд цаашид юу бичвэл зохих талаар санал бодлоо илэрхийлж байдаг юм.

Зарим уншигчид сонирхон буй сэдвээрээ асуулт тавих ч удаа байдаг. Бид уншигчдынхаа санал бодлыг байнга анхаарч сонирхсон асуултанд нь бололцооны хирээр хариу өгөхийг хичээх бөгөөд энэ зорилгоор 1989 оны дугаараас эхлэн «лавлах» булан нээхээр төлөвлөж байна.

Уншигчдын энэ мэт санал зөвлөгөө тус сэтгүүлийн редакцийн ажилд чухал хувь нэмэр болох учир уншигчдаас цаашид ч санал хүсэлтээ өргөн ирүүлнэ гэдэгт итгэж байна. Сэтгүүлд ирсэн захидлаас заримыг дор нийтлэв.

«Дорно дахины судлалын асуудал» сэтгүүлийн редакцид

Сэтгүүлийн хамт олны амар мэндийг эрж, эрүүл энх, сайн сайхныг хүсье. Миний бие хөдөө орон нутагт олон жил захирал, багш, суртал нэвтрүүлэгч, намын ухуулагчаар ажиллав. Танай сэтгүүлийг шинжлэх ухаан, нийгэм улс төрийн чухал сэтгүүл гэж үздэг. Яагаад гэвэл хөдөлмөрчдөд яриа таниулга хийхэд танай сэтгүүлийг юуны урьд ашигладаг юм.

Азийн улс түмний түүх, соёл, Ази, Номхон далайн бүс нутгийн энх тайван, аюулгүй байдал, БНМАУ-ын гадаад бодлого, орчин үеийн харилцааны асуудлаар чухал өгүүлэл нийтлэгдэж байгаа явдалд талархаж байна

1987—1988 оны хичээлийн жилд ХАА-н ТМДС-ийн сурагчдад улс төрийн хүмүүжил олгох зорилгоор 600 гаруй хүүхдэд танай сэтгүүлийг сурталчлах ажил зохиов. Миний хувьд уг сэтгүүлийг дугаар дараалан хадгалж лекц ярианы сэдэв бичихэд ашигладаг юм,

Манай сургууль жил бүр «Ухуулагч». «Намын амьдрал», «Хүүхдийн хүмүүжил», «Дорнодахины судлалын асуудал», «Соёл» сэтгүүлийг сурталчлан төлөвлөгөө гаргаж уншигчдын бага хурал, ярилцлага зохиосон нь үр дүнгээ өгч байна.

Та бүгдэд ажлын амжилт хүсье.

**Сэлэнгэ аймаг, Цагаан толгой дахь ХАА-н
ТМДС-ийн орлогч захирал Ё ТӨМӨРБААТАР.
1988. 6. 29.**

ТАВИЛГҮЙ УНШИЖ ДУУСГАДАГ

Би «Дорнодахины судлалын асуудал» сэтгүүлийг анх хэвлэгдсэн цагаас захиалан уншиж байна. Тэгэхдээ би түүхч, эрдэм шинжилгээний ажилтан биш. Харин түүх; угсаатны судлалыг сонирхдог хүн. Тус сэтгүүлийн хуудсанд миний сонирхдог олон асуудал бичигддэг, сэтгүүлийн чанар чансаа сайн байдагт тэгдэг байх,

Би төв орон нутгийн нэлээд хэвлэлд 30-аад жил мэдээ материал бичиж байгаа жирийн бичигч хүн. Харин танай сэтгүүлд гэхэд би юу бичих вэ дээ. Сэтгэгдлээ л бичье гэж бодлоо. Харин түүх, соёл, угсаат-

ны зүй сонирхогчийн хувьд юу бичиж мэдээлж болох талаар зөвлөвөл би баяртай хүлээж авна.

Тус сэтгүүлд нийтлэгдсэн «Монголын төр ёсны уламжлалын асуудал», «МЭӨ 185 онд бичсэн хүннүгийн хааны захидал, «Төв Азийн олон улсын соёлын харилцааны эртний түүхээс», «Соёмбо үсэг сүлд тэмдэгийн холбоо» зэрэг материал их таалагдлаа.

Өнөөдрийн өөрчлөлт шинэчлэлийн нөхцөлд уншигч би өөрийн санал бодлоо хэлье гэж бодлоо.

Юуны урьд сэтгүүлийн гарах, хугацааг богиносгон захиалагчийг ихээхэн өргөжүүлмээр байна.

Энэ үгийг тус сэтгүүл захиалагч цөөтэйгээс бэл хөл багатай болов уу гэсэн санаанаас огт биш, харин түүх, угсаатны судлал, дорнодахины асуудлыг өргөн олонд сурталчлах санааны үүднээс хэлж байна.

Сэтгүүл жилдээ хоёрхон удаа гарч байгаа нь уншигч биднийг үнэхээр «цангааж» байна.

Уншсан сэтгүүлээ найз нөхөддөө уншуулж сэтгүүлээс үзсэн дуулснаа бусдад ярих дуртай. Тийм сэтгүүл байдаг юм уу гэж хэлэх хүн ч тааралдах юм.

Иймд сэтгүүлийн редакци уг сэтгүүлийн уншигчдын бага хурлыг орон нутагт хийх, бусад сонин сэтгүүлд танилцуулга бичих, түүх, утга зохиолын багш нараар захиалуулж сурталчлах, сэтгүүлийн оны шагнал бий болгох, хамгийн олныг захиалуулсан хэвлэлийн төлөөлөгч нарыг шагнаж урамшуулах, түүх угсаатны судлал, дорнодахины асуудал сонирхогч нараар сэтгүүлдээ өргөн бичүүлэх ажил зохиовол зүйтэй гэж боддог. Мөн хугацаандаа хэвлэн гаргах талаар ч их анхаармаар байна. Ирэхийг тэсч ядан сураглан хүлээж байж ирмэгц зав л гарвал тавилгүй уншиж дуусгах тийм л сонирхолтой сэтгүүл гэж боддог. Улс орныхоо түүх, соёл, ард түмний зан заншил, уламжлалаа мэдэхгүйгээр хэн ч эх орноороо бахархаж чадахгүй. Бахархах зүйлгүй улс орон ч гэж байхгүй.

Үнэхээр их бахархах түүх соёлтой, өвөрмөц зан заншил, уламжлалтай орны нэг бол Монгол орон гэж би боддог. Тийм орныг сурталчлах, эртний соёлт дорно дахины түүх, соёлыг ард түмэндээ танилцуулах, энэ талаар гарч буй ном зохиол, бүтээлийг сурталчлах үйлсдээ сэтгүүлийн редакци, тус сэтгүүлийн идэвхтэн бичигч эрдэмтэн мэргэдэд нийтлэлийнхээ ажилд их амжилт олохыг хүсэн ерөөе!

**Өмнөговь аймгийн Нэгдэл дундын орлогч
дарга Д. ХҮҮХЭНГАА 1988. 11. 15.**